



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,
Утас: 51-263051, Факс: (976) 7004-3479
E-mail: info@energy.gov.mn

2021.12.31 № 4/4649
танай 2021.12.17-ны № 46 -т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлын явц, түүнтэй холбоотой асуудлаар ирүүлсэн асуулгатай танилцаад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Power Construction Corporation of China Ltd болон POWERCHINA Chengdu Engineering Corporation limited" компанийн түншлэл шалгарч, Эрчим хүчний яамтай 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр ЭХА-14/2021 дугаартай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг байгуулсан. Тус компани барилга угсралтын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа ба 2026 онд дуусган, шинээр усан сан үүсгэж, 2027 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байна.

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны "Үнэлгээний мэргэжлийн зөвлөл"-ийн 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, хурлаас өгсөн зөвлөмжийн дагуу төслийн нөлөөлөлд өртөж буй засаг захиргааны нэгжийн иргэдтэй хэлэлцүүлэг хийж, тайланг 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр батлуулсан.

Тус тайланд төслийг хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан 28000 га газраас 9871.1 га газарт шинээр усан сан үүсэх ба үүнээс Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын гурван багийн 5182.3 га газар нутагт амьдарч буй 145 өрх, Увс аймгийн Өмнөговь сумын Улиастай багийн 4576 га газар нутагт амьдарч буй 125 өрх буюу нийт 270 өрх төслийн нөлөөлөлд өртөхөөр байгаа талаар туссан.

Эдгээр 270 өрхийг 2022-2025 онд үе шаттайгаар одоо амьдарч буй нөхцөлийг дордуулахгүйгээр нүүлгэн шилжүүлэхээр орон нутгийн засаг захиргааны нэгжтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2022 онд нийт 91 өрхийг нүүлгэн шилжүүлэх санхүүжилтийг Улсын төсөвт тусгуулсан болно.

Нөхөх олговрыг Газрын тухай хууль болон тус хуульд нийцүүлэн Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор баталсан "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам"-ын 4.1-д "Нөлөөлөлд өртөж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшлийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн солих буюу эргүүлэн авах тохиолдолд Газрын тухай хуулийн 18.1.3-т заасны дагуу нөхөх олговор олгоно" гэж, 4.3-т "...нөхөх олговрыг

170602982

тооцохдоо нөхөх олговортойгоор эргүүлэн авах буюу солих газрын хил зааг, байршил болон тухайн газраас салгаж үл болох барилга байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгийн талаарх схем зургийг үндэслэл болгоно” гэж, 4.4.1-д “иргэний өмчлөлийн газрыг сольж олгох тохиолдолд иргэний хүсэлтийг үндэслэн өмчилж байгаа газраас нь төлөв байдал, чанарын хувьд дордохооргүй газар олгох” гэсэн эрх эрх зүйн зохицуулалттай.

Төслийн нөлөөлөлд өртөж буй дийлэнх иргэд газар өмчлөх, эзэмшлийн гэрчилгээгүй байгаа нь дээрх журмын дагуу иргэдийн газрыг үнэлэх, нөхөх олговрыг ижил төвшинд тогтооход хүндрэл учруулж байна.

Нөхөх олговрыг олгох эрх зүйн боломжийг Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн нөлөөлөлд өртөж буй иргэдэд тухайлан бүрдүүлж шийдвэрлэх боломжтой бөгөөд ойрын хугацаанд энэхүү асуудлыг зохицуулах нэг удаагийн тусгай зохицуулалтыг тусгасан журам боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр төлөвлөж байна.

Уг журам батлагдсанаар төслийн нөлөөлөлд өртөж буй иргэдэд ижил тэнцүү нөхөх олговор олгох таны саналыг судалж, шийдвэрлэх боломжтой болох юм.

Түүнчлэн нөлөөлөлд өртөж буй иргэдийг нүүлгэн шилжүүлэх олон улсын туршлагын дагуу малчдын амьжиргааг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах бөгөөд шинээр усалгааны системтэй малын тэжээлийн ургамал тарих талбай болон бэлчээрийг бэлтгэх, малчдын тодорхой саналд үндэслэн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжийг бүрдүүлэх зэрэг ажлуудыг цогцоор хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

2. Монгол Улсын Их Хурлаар 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр соёрхон баталсан Монгол Улсын Сангийн яам болон БНХАУ-ын Экспорт-Импорт банк хооронд 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан “БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг ашиглах тухай Зээлийн ерөнхий хэлэлцээр” болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулсан.

Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй байгуулсан түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээнд “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн 5.3.1-т заасны дагуу “Хятадын талд ногдох хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн тавин хувиас (50%) багагүй байна. Монголын тал болон гуравдагч талд ногдох хэмжээ нь Төслийн гэрээний үнийн дүнгийн тавин хувь (50%)-тай тэнцүү буюу ихгүй байна” гэж туссан. Үүний дагуу тендерт шалгарсан барилга угсралтын ажлын гүйцэтгэгч компаниас Монгол Улсын дотоодын бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авах үүрэгтэй.

Эрчим хүчний яамны зүгээс төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компанийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, тодорхой аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллахыг тулгах боломжгүй юм.

Зээлийн ерөнхий хэлэлцээр болон түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээний дагуу барилга угсралтын ажлын гүйцэтгэгч компанид орон нутгаас ажиллах хүч, барилгын материал болон хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх, хилийн боомтоос төслийн талбар хүртэлх тээвэр, төслийн талбарыг цахилгаан эрчим хүчээр хангах

зорилгоор 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих зэрэг ажлуудад Монгол Улсын оролцоог хангах саналыг хүргүүлэхээр төлөвлөж байна.

Иймд дээрх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэдэг аж ахуйн нэгж, иргэдийн мэдээллийг нэгтгэн ирүүлэх талаар орон нутгийн засаг захиргааны нэгжид уламжилж хамтран ажиллахыг хүсье.

3.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баригдах Ховд гол нь Алтай Таван Богд уулын баруун урд хажуугийн мөсөн голоос эхтэй хэд хэдэн гол горхи цутгах Хотон, Хурган нуураас эх авч урссаар Хар ус нуурт цутгадаг, Монгол Улсын гадагш хил дамжин урсдаггүй гол тул хилийн усны талаар ямар нэг маргаангүй гол юм.

Нөгөөтэйгүүр төслийн байгаль орчин, орон нутгийн иргэдэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, хөндлөнгийн хяналт зэргийг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай” хуулиар зохицуулсан байдаг.

Энэхүү хуулийн хүрээнд Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны Ерөнхий шинжээчийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 13/7381 дугаартай “Байгаль орчны Ерөнхий үнэлгээний дүгнэлт” гарч, “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх”-ээр шийдвэрлэсэн.

Төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг улсын төсвийн хөрөнгөөр эрх бүхий мэргэжлийн “Ньюгидропроект” ХХК болон “ЭНКО” ХХК-ийн түншлэл гүйцэтгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, мэргэжлийн зөвлөлийн зөвлөмжийн дагуу төслийн нөлөөлөлд өртөж буй Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Баяннуур баг болон Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн иргэдтэй уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, тэдний санал хүсэлтийг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгаж, батлуулсан.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл нь ямар нэгэн хилийн усны маргаангүй тул байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг олон улсын хараат бус, хөндлөнгийн байгууллагаар дахин хөрөнгө зарцуулж хийлгэх шаардлагагүй юм.

САЙД



Н. ТАВИНБЭХ